



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/54

Алтлага

“Хариуцлагатай газрын харилцаа”
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5³.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Салбарын хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчилах, газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанаас газар түүний хөрсөнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хариуцлагатай газрын харилцаа” аяныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Аяныг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Аяныг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (М.Одхүү), газрын даамал (Д.Батсайхан) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА  Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010121